

## Жамсрангийн Цэвээн монголын түүх бичлэгт

Докторант С.Тувшин

Жамсрангийн Цэвээн бол Монголын түүхэнд үүрд дурсагдах түүхт хүмүүн юм. Ийм учраас Монголын түүх судлалд түүний нэр, амьдрал, үйл ажиллагааны олон талыг хөндөн судлаж ирсэн байна. Монголын төр, нийгмийн зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, нэрт эрдэмтэн Ж.Цэвээний амьдрал, үйл ажиллагааг Монголын түүх бичлэгт манай орны судлаачид хэрхэн яаж авч үзэж ирснийг дараах үндсэн үечлэлээр авч үзэж болно. Үнд:

1. **Ж.Цэвээний амьдрал, үйл ажиллагааг марксист байр сууринаас өрөөсгөлөөр үнэлж ирсэн нь.** (1930-1980-аад оны сүүлч) Ц.Цэвээн 1920-иад онд МАХН, төрийн удирдах албан тушаалд дэвшин ажиллаж, Монгол орны хөгжлийн хэтийн төлөвийн талаар үндэсний ардчилсан үзлийн байр сууринаас үзэл бодлоо илэрхийлж байв. Энэ нь түүнийг "баруунтан" хэмээн зэмлэгдэх үндэс болсон билээ. Θ.Бадрах 1932 онд нийтлүүлсэн "Намаас баруун бөөрөнхийчүүд лүгээ тэмцсэн амжилттай их тэмцлийн туршлага" хэмээх бүтээлийн "Баруунтан ба тэдгээрийн шашныг шинэчлэх хэмээсэн байгууллагын ба ажлын зорилго үүсвэр хийгээд Цэвээн Жамсранов ба түүний хамт туслагчдын үйлдвэрийн тухай" гэсэн VIII бүлэгт Ж.Цэвээний улс төр, шашны үзэл, байр суурийг "барууны аюул" хэмээх үүднээс шүүмжилжээ. Түүний ярьсан хэлсэн зүйлийг Θ.Бадрах: "Бурхан Буддагийн шашны төлөөлөгч бөгөөд баруун бөөрөнхийчүүдийн багш болох Цэвээн Жамсрановын улилт" гэж тэмдэглэсэн байна.<sup>1</sup> Энэ үеэс Жамсрангийн Цэвээнийг "баруунтын онолч үзэл сурталч" хэмээн үзэж, түүний үйл ажиллагааг сөрөг талаас нь үнэлэх үнэлэмж Монголын түүх бичлэгт хаван нэвт шингэсэн юм.

1954 онд Монгол, зөвлөлтийн түүхчдийн хамтран бичсэн "БНМАУ-ын түүх"-ийн нэгэн боть зохиолд: Барууны хэлбэрчдийн үзэл сурталчдын нэг Жамсраны Цэвээн буддизмыг марксизмтай адилтгахыг оролджээ" хэмээн тэмдэглэсэн байна.<sup>2</sup>

БНМАУ-ын түүхийн гурамсан зохиолын III ботид: "Үндэсний үзэл бол баруунтын үзэл суртлын уг үндэс байсан бөгөөд тэдний үзэл санааг өөгшүүлэн элдэв аргаар ятган зорижжуулагч нь Ц.Жамсран байв. Ц.Жамсран жижиг хөрөнгөтний үндэсний үзлийг сурталдаж, МАХН-ын үзэл суртлын үндэс болсон марксизм-ленинизмийг шашинтай адилтгахыг оролдож байсан ба Монгол-Зөвлөлтийн харилцаанд сэжиг төрүүлэх явдлыг битүүлгээр дэмжих ятгаж байсан байна" гэжээ.<sup>3</sup> Түүнчлэн "МАХН-ын товч түүх"-энд: "...баруунтан ялангуяа тэдний үзэл сурталч Жамсраны Цэвээн шашны харгис чанарыг элдвээр бүрхэгдүүлэн түүний эсрэг суртал нэвтрүүлэг явуулахыг эсэргүүцэж, буддийн шашин намын үзэл сурталд харшлахгүй гэж номлон "шашныг ариунаар мандуулах"-ыг зүйл бүрээр сурталчилж байв" хэмээн зэмлэсэн байна.<sup>4</sup> Энэ бүхэн нь тухайн цагийн эрх баригч нам, төрийн үзэл суртал, ангич, намч байр суурь түүхийн судалгаанд газар авсны хаялга юм.

Улсын болон эрх баригч намын албан ёсны түүхэнд Ж.Цэвээний амьдрал, үйл ажиллагааг авч үзсэн дээрх байр суурь цаашдын түүхийн судалгаанд гол зарчим, мөрдлөг болон хэрэгжиж байв.

Үүнийг "БНМАУ дахь үзэл суртлын тэмцлийн түүхэн туршлагаас" (УБ.1985), Б.Лхамсүрэнгийн "МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь" (УБ.1975), Д.Дашжамцын "Марксизм-ленинизм Монголд дэлгэрэн хэрэгжсэн нь" (1917-1940 он) (УБ. 1973) зэрэг бүтээлүүдээс харж болно.

<sup>1</sup> Θ.Бадрах. Намаас баруун бөөрөнхийчүүд лүгээ тэмцсэн амжилттай их тэмцлийн туршлага. УБ. 2001. 174 дахь тал.

<sup>2</sup> БНМАУ-ын түүх. Завсарлаж нэмсэн хоёр дахь удаагийн хэвлэл. УБ. 1966.336 дахь тал

<sup>3</sup> Мөн тэнд. Тал 247

<sup>4</sup> МАХН-ын товч түүх. УБ.1967.118 дахь тал.

2. Ж.Цэвээний амьдрал, үйл ажиллагааг эрчимтэй судалж, нэр төрийг сэргээсэн ўе. (1990-ээд оноос эдүгээ хүртэл) 1980-аад оны сүүлч 1990-ээд оны эхээр өрнөсөн ардчилсан хөдөлгөөн монголчуудын чөлөөтэй сэтгэн бодох эрх, эрх чөлөөг нээж өгсөн юм. Түүхийн судалгаа, нийгмийн сэтгэлгээнд шинэ хандлага бий болов. 1980-аад оны төгсгөлөөс тус улсын сонин, хэвлэлд Ж.Цэвээний амьдрал, үйл ажиллагааг түүхийн үнэний үүднээс сэргээх алхмууд хийгдэж эхэлжээ. Зарим зохиолч, сэтгүүлч, нийтлэгчдийн дурсамж яриа, өгүүлэл гарах болов\*.

Хөгжлийн шинэ үеийн эхэнд Ж.Цэвээний тухай судалгааны шинжтэй томоохон өгүүлэл бичсэн эрдэмтэн бол профессор Лу.Бат-Очир, түүхч Д.Уламбаяр нар юм. Тэд "Жамсрангийн Цэвээний социализмын тухай үзэл" хэмээх өгүүлэлдээ түүний үзэл санааны төлөвшил, "Хоршооллын социализм"-ын үзэл санааны мөн чанар, агуулгыг түүх шинэчлэлийн үүднээс задлан шинжилсэн бөлгөө.<sup>5</sup>

1990-ээд оны II хагаст Ж.Цэвээний амьдрал, үйл ажиллагааны талаархи судалгаа эрчимжжээ.

Эрдэмтэн Д.Дашжамц "Нэрт эрдэмтэн, нийгмийн зүтгэлтэн" хэмээх өгүүлэлээ "Түүхийн хүрд" сонинд хэвлүүлж, түүнийгээ өргөтгөн, "Ж.Цэвээн монголын үндэсний хувьсгал, нам, төрийн үйлсэд", "Ж.Цэвээн-монголын нэрт соён гэгээрүүлэгч", "Ж.Цэвээн-манай нэрт нийтлэгч сэтгүүлч болох нь", "Ж.Цэвээн бол монголын шинжлэх ухааны үйлс" гэсэн дэд сэдвүүдэд бодролоо төвлөрүүлэн, сайхь зүтгэлтний амьдрал үйл ажиллагааг Ж.Цэвээний "Түүвэр зохиолиуд"-ын I ботийн эхэнд нэлээд цэгтэй хураангуйлан дүгнэжээ.<sup>6</sup>

Ж.Цэвээний амьдрал үйл ажиллагааг эрдэм шинжилгээний өгүүлэлийн хэмжээнд төдийгүй, нэгэн сэдэвт зохиол, товхимол, эрдмийн зэрэг горилох бүтээлийн хэмжээнд судлах болов. Түүхч Ж.Цэцэгмаа сайхь төр, нийгмийн зүтгэлтэн, эрдэмтний Монгол дахь шинжилгээ, судалгаа, соён гэгээрүүлэх болон нийгэм-улс төрийн үйл ажиллагааны талаар түүхийн ухааны доктор (Ph)-ын зэрэг Улаан-Үд хотноо хамгаалж, хэд хэдэн ном, өгүүлэл бичсэн байна. Тэрбээр "Эрдэмтэн Жамсрангийн Цэвээний Монголд ажилласан он жилүүд" бэсрэг товхимолдоо: Монголын нам, төр, соёл, шинжлэх ухааныг хөгжүүлэх, ард түмнийг соён гэгээрүүлэх аугаа буяны үйлсийг бүтээсэн алдарт эрдэмтэн Жамсрангийн Цэвээний Монголын ард түмний төлөө хэрхэн зүтгэж, бие сэтгэлээ зориулж ажилласан тухай хол, ойрын түүх баримтыг нягтлан судалснаа уншигч олноо толилуулж байгааг тэмдэглэсэн байна.<sup>7</sup> Мөн доктор Ж.Цэцэгмаа (Ph), Буриадын нэрт эрдэмтэн Д.Б.Ульямжиевтай хамтран "Цыбен Жамцаано: научная, просветительская и общественно-политическая деятельность в Монголии (1911-1931 гг.)" Улан-Үдэ 1999" хэмээх нэгэн сэдэвт зохиол туурвижээ. Уг нэгэн сэдэвт зохиолын өлгөц танилцуулгад: Орос дахь Монгол судлал хамгийн эртний нэг салбарын нэг юм. Түүний үүсэл, хөгжил нь дэлхийн хэмжээний дорно дахиныг судлаач-тomoохон эрдэмтдийн нэртэй холбоотой. Түүний нэгэнд Жамсрангийн Цэвээн (1881-1942) багтах нь эргэлзээгүй. Сайхь эрдэмтний үйл ажиллагаа Орос, Монголын төр, нийгэм, улс төрийн хөгжлийн түүхийн янз бүрийн ўе шатанд гүнзгий ул мөрөө үлдээжээ. Бараг 20 жилийн турш (1911-1917, 1920-1931) хувь заяаны эрхээр Жамсрангийн Цэвээн Монголтой холбогдсон юм. Энэ үеийн түүний амьдрал, үйл ажиллагаа одоо хүртэл бага судлагджээ. Чухамхүү эл нэгэн сэдэвт зохиол Жамсрангийн Цэвээний Монгол дахь шинжлэх ухаан, соён гэгээрүүлэх болон нийгэм-улс төрийн үйл ажиллагааны асуудлыг хөндөн судлахад чиглэгдсэн юм.

\* Ц.Дамдинсүрэн. "Хууч яриа дурсамж". //Цог сэтгүүл.1988.№6. Л.Лувсанчултэм. Жамсрангийн Цэвээн "Утга зохиол, урлаг" сонин. 1989.№18. Т.Мандир, Н.Нагаанбуу. Мартагдсан монгол. "Ардчилал" сонин. 1990.№3. "Д.Уламбаяр. Соён гэгээрүүлэгч "Улаан од" сонин. 1990.№78. Б.Содов. Цэвээн Жамсранов. "Үндэсний дэвшил" сонин. 1991.№13.

<sup>5</sup> "Дорно дахины судлалын асуудал" сэтгүүл.1990.№1.

<sup>6</sup> Жамсраны Цэвээн. Түүвэр зохиолууд. I боть.УБ. 1997. (эмхтгэсэн С.Идшинноров) 5-16 дахь тал.

<sup>7</sup> Ж.Цэцэгмаа. Эрдэмтэн Жамсрангийн Цэвээний Монголд ажилласан он жилүүд. УБ. 1999 он.

Энэ бүтээлийг зохиогчид нь Оросын шинжлэх ухаан, урлагийн академийн жинхэнэ гишүүн, Оросын холбооны улсын шинжлэх ухааны гавьяат ажилтан, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Д.Б.Улымжиев, Монгол Улсын "Их Засаг" дээд сургуулийн ахлах багш, түүхийн ухааны доктор Ж.Цэцэгмаа (PhD) нар болой. Зохиолд уг асуудлыг түүхэн чиглэлээр бүх талаас нь хөндөн судалсан байна"<sup>8</sup> гэжээ. Энэ бүтээлийг туурвидаа Оросын шинжлэх ухааны академийн Дорно дахины хүрээлэнгийн Петербургийн салбарын Дорно дахиныг судлаачдын архивт буй Жамсрангийн Цэвээний гар бичмэлийн сан, Оросын бусад архивууд, Монгол улсын үндэсний архив, МАХН-ын архив, Монгол улсын нийтийн төв номын санд буй Ж.Цэвээний амьдрал, үйл ажиллагаатай холбоотой материалиудыг шүүрдэн ашиглажээ. Түүнээс гадна Ж.Цэвээний амьдрал, үйл ажиллагааны талаар орос, монголын судлаачдын бүтээлийг бараглан дун шинжилгээ хийснийг дурьдах ёстой. Доктор (Ph) Ж.Цэцэгмаа сүүлийн жилүүдэд бас сайхь эрдэмтний талаар эрдэм шинжилгээний бичиг болон сонин, сэтгүүлүүдэд хэд хэдэн сонирхолтой өгүүлэл нийтлүүлснийг дурьдю.<sup>9</sup>

Түүнээс гадна монголын эрдэмтэд Жамсрангийн Цэвээний үзэл баримтлалыг нэгэн сэдэвт зохиол болон судалгааны хэд хэдэн өгүүлэлдээ хөндөн тайлбарласан байна. Доктор (Sc) О.Батсайхан "Монгол улсын хөгжлийн замд учирсан ээдрээ" (1921-1932) хэмээх бүтээлийнхээ олон бүлэг зүйлд Ж.Цэвээний үзэл бодол үйл ажиллагааг хөндөн үзсэн байна.<sup>10</sup> Доктор, профессор Ж.Болдбаатар "Үндэсний ардчилсан хувьсгал ба Монгол орны хэтийн төлөвийн тухай үзэл баримтлал" хэмээх өгүүлэлдээ: "Ж.Цэвээний хоршооллын социализмын үзэл баримтлал нь хожим Ази, Африкийн орнуудад дэлгэрсэн" үндэсний социализм"-ын марксист бус үзэл санаатай ойролцоо бөгөөд түүний хамгийн анхны илрэл байсан бололтой. Чухам энэ утгаар нь Ж.Цэвээний "Гуравдагч ертөнцийн тухай" онолыг үндэслэгчдийн нэг ч гэж хэлж болохоор байна"<sup>11</sup> гэсэн сонирхолтой дүгнэлт хийжээ. Доктор /Ph/ Ш.Лувсандорж, докторант А.Энхбат өгүүлэлдээ Жамсрангийн Цэвээний үндэсний социализмын үзэл санааны мөн чанар, агуулгыг задлан шинжилжээ.<sup>12</sup> Энэхүү өгүүлэлийг чадан ядан тэрлэгч би МУИС-ийн "Түүх" сэтгүүлд "Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд" хэмээх нэгэн өгүүлэл хэвлүүлснээ дурьдсу.<sup>13</sup>

Ж.Цэвээн судлалд сүүлчийн жилүүдэд гарсан томоохон олз бол түүний түүвэр зохиолуудыг хоёр ботиор эмхтгэн гаргасан явдал юм. Эл эмхтгэл хийх буянтай үйлсийг санаачлан эрхэлсэн доктор (Ph) С.Идшинноров: "Ж.Цэвээн бие сэтгэлээ Монголын төлөө зориулж, нийгмийн амьдралын салаа бүрт сурсан мэдсэнээ хэрэгжүүлэн, хоцрогдсон буурай Монголыг өөд татахыг чармайж байлаа. Тийм ч учраас Ж.Цэвээний тухайн үеийн Монголын оюуны эцэг гэж үздэг" хэмээгээд гол гол бүтээлүүдийг уншигч олны оюуны мэлмийд өргөн барьсан байна.<sup>14</sup>

Монголын түүх бичлэг дэх Ж.Цэвээний талаарх манай орны судлаачдын бүтээлээс үзэхэд, түүний амьдрал, үйл ажиллагааны өрөнхий дүр төрхийг нэлээд ул суурьтай гарган тавьж чаджээ. Өдгөө улам бүр нарийвчлан судалгаа хийх шаардлагатай байна. Тухайлбал, түүний нийгэм—улс төрийн үзэл санааны төлөвшил, Монгол орны хөгжлийн талаарх үзэл баримтлалыг түүх онолын үүднээс задлан шинжлэх, монголын түүх угсаатны зүйн судалгаанд оруулсан хувь нэмрийг тусгайлан авч үзэх, улс төрийн

<sup>8</sup> Д.Б.Улымжиев, Ж.Цэцэгмаа. Цыбен Жамсрано: 'Научная, просветительская и общественно-политическая деятельность в Монголии. (1911-1931г)" Улан-Үдэ.1999.)

<sup>9</sup> Ж.Цэцэгмаа. Шинжлэх ухаан, улс төр, олон нийтийн зүтгэлтэн Ж.Цэвээн. "Их Засаг", онол, эрдэм шинжилгээ арга зүйн сэтгүүл. 2002.№6.76-78 дахь тал

<sup>10</sup> О.Батсайхан. Монгол улсын хөгжлийн замд учирсан ээдрээ. (1921-1932) УБ.1997 он.

<sup>11</sup> МУИС-ийн НУФ-ын эрдэм шинжилгээний бичиг. №4.(133) УБ. 1998. 185 дахь тал.

<sup>12</sup> Монголия, Бурятия, Тыва, Иркутская область: развитие, взаимодействие и вызовы внутри и вокруг Байкальского региона. УБ., 2002. с 71-77.

<sup>13</sup> МУИС-ын НУФ-ын эрдэм шинжилгээний бичиг "Түүх" №188.(14) 2002 он. 68-71 дэх тал.

<sup>14</sup> Ж.Цэвээн. Түүвэр зохиолууд, УБ.1997. 4 дэх тал. Ж.Цэвээн. Түүвэр зохиолууд. УБ.2000 он.

зүтгэлтний шинж төрхийг түүх, улс төрийн шинжлэх ухааны бэлчир зангилаан дээр тодорхойлох, монголын боловсролын хөгжилд хүчин зүтгэсний үр дүн, өгөөж, хаялгыг үнэлэх зэрэг өдий төдий асуудал судлаачаа хүлээж байна. Ер нь Ж.Цэвээний бүтээл туурвил нь судалгааны чухал хэрэглэгдэхүүн, яндашгүй эх булаг, баялаг өв билээ.

**“J.Tseveen in Mongolian Historiography.”**

*By S.Tuvshin.*

**Summary**

This article touched the issue of Jamsarno Tseveen in Mongolian Historiography. J.Tseveen was the emeritus scholar and statesman at the first half of the XX century. His contribution to the Mongolian studies and legislation development is renown. The Mongolian historiography could be divided in two parts: the negative part is historiography about 1920-1980s and positive since 1990.